



ДОРНОГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 1/99

Хонгор

Газар эзэмшүүлэх төсөл сонгон
шалгаруулалт зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам", Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 120 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 2/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-д тусгагдсан малчдын хоршоонд Цагаанхад багийн нутаг дэвсгэрт орших Улаан овооны голын бууц хаягт мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар 15000 м² газрыг 15 жилийн хугацаатай төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэхээр баталсугай.

2. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Газрын даамал (И.Болортуяа)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (М.Ганбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТХҮҮ

4425010251